# Алт хайхад ТАНД ХАМГИЙН ШИЛДЭГ НЬ ХЭРЭГТЭЙ!

GPX5000

Having 8 Soil/Timings is like having

8 detectors in 1

GPX4800

Having 6 Soil/Timings is like having

6 detectors in 1

GPX-н горимууд илрүүлэгч дэх электрон эд ангийн дижитал сэлгэлт, боловсруулах үйл ажиллагаар сольдор. Тодорхой нөхцөлд хамгийн оновчтой ажиллах зорилгоор горим бүрийг зохион бүтээсэн. Та шинэ горим бүрийг сонгох бүрдээ өөр илрүүлэгчтэй ажиллаж байгаа мэт санагдана.

**Горимын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл эргүүлнэ үү**




## Техникийн үзүүлэлт







### Ажиллуулах онцлог (Нийтлэг функц)

| | GPX5000 | GPX4800 |
|---|---|---|
| Урьдчилан тохируулсан хайх горим | 6 горим: Ерөнхий, гүн, их эрдэсжсэн, зурвас газар, их хогтой, нарийвчилсан | 3 горим: Ерөнхий, гүн, их эрдэсжсэн |
| Хөрс мэдрэх горим | 8 горим:Маш жижиг алт, давслаг/алт, мэдрэмтгий, зоос/эртний зүйлс, хэвийн, илүү мэдрэмтгий, сайжруулсан, хурц | 6 горим:Зоос/эртний зүйлс, давслаг/том хэвийн, илүү мэдрэмтгий, сайжруулсан, хурц |
| Тавгийн Rx тохиргоо | Цуцлах, Mono, Double-D | |
| Хайлтын тэнцвэрийн төрөл | (3) Ерөнхий, тодорхой, унтраах | (2) Ерөнхий, унтраах |
| Хурдан мэдрэх бариул | Бариул дээрх хурдан мэдрэх товч | |
| Цахилгааны саад | Автомат дардаг товч, гараар тохируулах (0-255) | |
| Босгоны түвшин | 1 эргүүлэгтэй хувьсах тохируулагч | |
| Дууны хүчний хязгаар | 1–20 | |

### Ажиллуулах онцлог (Тухайн горимд хамаарах функц)

| | GPX5000 | GPX4800 |
|---|---|---|
| Хөдөлгөөн | (4) маш удаан, удаан, дунд, хурдан | (3) маш удаан, удаан, дунд |
| RX Gain | 1–20 | 1–15 |
| Дууны төрөл | (4) Чимээгүй, хэвийн, чанга, хэт чанга | (3) Чимээгүй, хэвийн, чанга |
| Дууны хэмнэл | 1–100 | |
| Тогтворжуулагч | 1–20 | 1–10 |
| Дохионы оргил | 1–20 | |
| Объектын дууны хүч | 1–20 | |
| Хариу | (2) Хэвийн, тонгоруулсан | (1) Хэвийн |
| Мэдрэх хурд | 3 мэдрэх хурдтай - удаан, дундаж, хурдан (мөн тогтмол | |
| Төмрийг ялгах функц | Унтраах (Бүх металл),1–10 | |

### Төхөөрөмжийн онцлог

| | GPX5000 | GPX4800 |
|---|---|---|
| Урт | 1100 мм-ээс (43.3") 1300 мм (51.2") хүртэл сунгах боломжтой | |
| Илрүүлэгчийн жин | 2.4 кг (5.3 фунт) 11” тавгийг оролцуулан (зай, тоноглол ороогүй) | |
| Зайны жин | 780 гр (1.7 фунт) | |
| Зайны төрөл | Литийн ионтой цэнэглэдэг зай 68Wh чанга яригчийг ашиглах зориулалттай өсгөгчтэй | |
| Зайны түвшин заагч | Хүчдэлийн түвшин заагч (мөн зай бага байгааг анхааруулах дохио | |
| Чихэвчийн төрөл | Koss UR30, 100 Ω  6.35 мм (¼”) чихэвчийн залгуур | |
| Таваг | 11” дугуй Double-D таваг<br>11” дугуй Monoloop таваг | 11” дугуй Double-D таваг |
| Дэлгэц | 43 x 26 мм (128 x 64 пиксел) арын гэрэлтүүлэгтэй ТБД | |
| Арын гэрэлтүүлэгтэй ТБД | 10 секунд өнгөрөхөд унтрахаас эхлээд байнга асаастай байхаар тохируулах боломжтой (8 байрлал) | |
| Дамжуулалт | Хоёр түвшний пульсын индукц | |
| Технологи | Олон үет мэдрэмж (ОҮМ), Хос хүчдэлийн технологи (ХХТ), Ухаалаг электрон горимын тохируулга (УЭГТ) | |
| Monoloop нэмэлт таваг | 8” дугуй, 11” дугуй (GPX 5000-д стандарт), 15” x 12” зууван, 18” дугуй | |
| Double-D нэмэлт таваг | 10” x 5” зууван, 15” x 12” зууван, 18” дугуй | |
| Авах боломжтой бусад тоноглол | Үүргэвч, багаж, олдворт зориулсан цүнх | |
| Барааны тэмдэг | MINELAB ® GPX ® MPS ™ DVT ™ SETA ® | |

### Commander таваг

COMMANDER



*Танд хамгийн ойр байрлах Minelab компанийн албан ёсны борлуулагч руу залгаж, Minelab компанийн жинхэнэ тавгийн танилцуулга аваарай*

### Танай улс дахь борлуулагч:

*Нэмэлт мэдээлэл авч, бүтээгдэхүүний интерактив танилцуулга үзэхийг хүсвэл* **www.minelab.com** *вэбсайтыг үзнэ үү.*

MINELAB
www.minelab.com

**Minelab Electronics ХХК**
118 Хэйуордын өргөн чөлөө,
Торензвил хот
Аделаид хот, Өмнөд Австрали 5031
**Австрали улс**
Утас: +61 (0)8 8238 0888
Факс: +61 (0)8 8238 0890
Имэйл: minelab@minelab.com.au

**Minelab International ХХК**
**(Европ, Ойрх Дорнод, Африк)**
207-р тасалгаа,
Харбор Пойнт бизнесийн парк
Литл айлэнд, Корк гүнлэг
**Ирланд улс**
Утас: +353 (0)21 423 2352
Факс: +353 (0)21 423 2353
Имэйл: minelab@minelab.ie

**Minelab Americas**
**(Хойд болон Өмнөд Америк)**
1938 Их сургуулийн гудамж, А байр
Лайл хот, Илинойс муж улс 60532
**АНУ**
Утас: +1 888 949 6522
Факс: +1 630 401 8180
Имэйл: info@minelabamericas.com

# GPX 5000 | 4800

## GPX Гүний давуу тал бүхий илрүүлэгчийг авч ИЛҮҮ ИХ АЛТ УЛАМ ГҮНЭЭС олоорой!




*“Эдгээр GPX илрүүлэгч бол Minelab компанийн үйлдвэрлэсэн хамгийн шилдэг нь бөгөөд... GPX 5000 илрүүлэгчийн шинэ Жижиг алт горим хүнд хэцүү хөрстэй нөхцөлд маш жижиг цул алтыг олох болно”.*

*2010 оны 8-р сар*

*Брус Кэнди*
*GPX илрүүлэгчийн зохион бүтээгч, ахлах эрдэмтэн*
*Minelab Electronics*

MPS DVT SETA

*Металл илрүүлэх дэлхийн хамгийн шилдэг технологи*

MINELAB
www.minelab.com

# GPX5000 | 4800

## GPX Гүний давуу тал

**Өндөр хүчин чадалтай GPX 5000, GPX 4800 илрүүлэгч өчүүхэн жижиг цул алтаас эхлээд "хувь заяаг өөрчилсөн" том гэх зэргээр янз бүрийн хэмжээтэй алт олох чадвартай!**

**ШИНЭ** сайжруулсан электрон эд анги, хөрс мэдрэх **ШИНЭ** горим, гайхамшигтай олон сонголттой онцлогууд хөрсний эрдэсжилтийн нэвт харах GPX-н домогт чадвартай хослоод бусад илрүүлэгчээс илүү гүнд ажиллах давуу талыг танд олгоно.

Өвөрмөц онцлог, функц, салбарын тэргүүлэх технологиудыг ашигласнаар GPX илрүүлэгч хамгийн хүнд хэцүү нөхцөлтэй хөрсөнд ч гэсэн саадгүй, чимээгүй ажиллахын зэрэгцээ цул алтыг илрүүлэх онцгой гүн, мэдрэмжээ хадгална.

Эхлэн суралцагчаас эхлээд мэргэжлийн хайгуулчинд хүртэл амар хялбар байх тул та үйлдвэрээс урьдчилан тохируулсан хайлтын горим, автомат функцийг ашиглан асаагаад шууд илрүүлэх боломжтой.

Хэрэв та хамгийн шилдэг алт илрүүлэгчийг хайж байгаа бол ҮҮНЭЭС ЦААШ ХАЙХ ХЭРЭГГҮЙ

**Хашир хайгуулчид GPX илрүүлэгч БҮХ төрлийн хөрсөнд өөр бусад ямар ч илрүүлэгчээс илүү гүнд алтыг олдог болохыг мэддэг!**

*Тийм ч учраас бидэнд*

***GPX-н гүний давуу тал байгаа гэж итгэлтэй хэлдэг!***






## GPX 5000 илрүүлэгчийн талбайн туршилтын үр дүн

**Талбайд хийсэн олон туршилтаар үр дүнг баталгаажуулсан.**



***Minelab компанийн талбайн туршилтын ажилтан, Баруун Австрали***
*Би энэ талбайд олсон бүх жижиг алтыг тоолоход одоогоор 419 ширхэг буюу 210 грамм байгаа бөгөөд тэр тусмаа талхалсан хөрс байсан!*

***Minelab компанийн талбайн туршилтын ажилтан, Викториа***
*Би GPX-4500 загварт дурлаад Minelab компанийн хамгийн сүүлд гарсан GPX 5000 алт илрүүлэгчийг турших болсондоо маш их сэтгэл хөдөлж байлаа. Сайжруулсан горимыг ашиглан хэд хэдэн цул алт олдсон нэгэн талхлагдсан зурвас газар луу би шууд явсан. 5000 загварын илрүүлэгч гайхалтай ажилласан. Төхөөрөмж тогтвортой, төгс хайлтын тэнцвэртэй байсан бөгөөд удалгүй цөөн хэдэн дохио өгч, маш жижигхэн цул алт илэрч эхэлсэн. Би итгэж чадахгүй байсан! GPX 5000 илрүүлэгч Жижиг алт горимд маш гайхалтай гүнд 0.4 -1.0 грамм цул алтыг саадгүй илрүүлж байсан бөгөөд Сайжруулсан, Хэвийн горимд дохиог бараг мэдрэхгүй байлаа. Ямар гайхамшигтай илрүүлэгч вэ!*



## Бүтээгдэхүүний танилцуулга

### GPX5000

**Улам олон шинэ онцлог, функц GPX 5000 загварыг дэлхийн шилдэг алт илрүүлэгч болгоно!**

- NEW **Хөрс мэдрэх 8 горим гэдэг бол** нэг дор 8 илрүүлэгчтэй ажиллахтай адил бөгөөд **БҮХ** төрлийн хөрсөнд улам их алт олно
- NEW **Жижиг алтны горим** Сайжруулснаас илүү гүнд, илүү мэдрэмжтэй хайж, бүрэн талхалсан гэж бодсон газраас ч гэсэн улам их цул алт олно!
- NEW **Давслаг/алтны горим** давслаг, эрдэсжсэн хөрсөнд том, жижиг цул алтыг илүү сайн олно. Далайн эрэг дээр мөн сайн ажиллана
- NEW **Зоос/эртний эд зүйлсэд зориулсан горим** бол хэвийн хөрсөнд тохирсон хамгийн гүнзгий нь юм
- NEW Объектыг илүү сайн мэдрэх, хайлтын тэнцвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор **электроник эд ангийг сайжруулсан** (улам Сайжруулсан горим багтана)
- Хүн бүр асаагаад хайж эхлэх энгийн ажиллагаанд зориулсан **үйлдвэрээс урьдчилан тохируулсан хайлтын 6 горим**
- Бүх нөхцөлд тохирсон **автомат хайлтын тэнцвэрийн** сонголттой
- Мэдрэмжийг илүү нарийвчлалтай тохируулж, хүчин чадлыг нэмэх боломж олгодог **сайжруулсан Rx Gain тохиргоотой**
- **Хөнгөн литийн ионтой зай**, өөрт нь суурилуулсан өсгөгчийн хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой
- **2 таваг** 11” Double-D таваг **мөн**11” Monoloop тавагтай




### GPX4800

**Илүү хэмнэлттэй боловч GPX 5000 илрүүлэгчийн ихэнх онцлог, ашиг тусыг агуулсан**

- **Хөрс мэдрэх 6 горим** нь нэг дор 6 илрүүлэгчтэй ажиллахтай адил бөгөөд янз бүрийн хөрсөнд илүү их алт олно
- NEW **Зоос/эртний эд зүйлсэд зориулсан горим** бол хэвийн хөрсөнд тохирсон хамгийн гүнзгий нь юм
- NEW Объектыг илүү сайн мэдрэх, хайлтын тэнцвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор **электрон эд ангийг сайжруулсан** (боловсронгуй болгосон Сайжруулсан горимтой)
- Хүн бүр асаагаад хайж эхлэх энгийн ажиллагаанд зориулсан **үйлдвэрээс урьдчилан тохируулсан хайлтын 3 горим**
- Бүх нөхцөлд тохирсон **автомат хайлтын тэнцвэрийн** сонголттой
- Мэдрэмжийг **тохируулдаг Rx Gain тохиргоотой**
- **Хөнгөн литийн ионтой зай**, өөрт нь суурилуулсан өсгөгчийн хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой
- 11” Double-D тавагтай






**ТБД бүхий цэсийн интерфейс**
Арын гэрэлтүүлэгтэй ТБД бүхий цэс Энгийн 2 хуваарь бүхий цэс удирдах систем

**Автоматаар тохируулах**
Цахилгааны саадыг зайлуулна. Мөн цэсээр дамжуулан гараар тохируулж болно.

**Босго**
Сулхан объектыг сонсох боломж олгохын тулд цаана сонсогдох чимээ анирыг тохируулдаг.

**Хайх горим**
Асаагаад шууд илрүүлэх зориулалтаар янз бүрийн хайлтын нөхцөлд тохирсон урьдчилан тохируулсан тохиргоог сонгоно.

**Хөрсний горим**
Янз бүрийн хөрс, объектын төрөлд тааруулж хамгийн дээд хүчин чадлаар ажиллахын тулд электрон эд ангийн дижитал сэлгэлт,боловсруулах үйл ажиллагааг өөрчилнө.

**Таваг/Rx**
Double-D тавгийн хайлтын хэв маягийг өөрчилж, тодорхой нөхцөлд хүчин чадлыг сайжруулна.

**Хайлтын тэнцвэр**
Хайлтын тэнцвэрийг хяналтын эсвэл тогтмол болгож сонгоно. Цэсээр тохируулах боломжтой хайлтын тэнцвэрийн төрөл, хянах хурдны сонголтыг ашиглан оновчтой болгож болно.

**GPX 5000 илрүүлэгчийн зураг**

## Технологийн танилцуулга

Minelab компанийн ОҮМ, ХХТ, УЭТТ технологи эдгээр GPX илрүүлэгчийг хамгийн хүчирхэг, хамгийн их мэдрэмжтэй болгоно.

**MPS** – Олон үет мэдрэмж технологи хөрсний эрдсийг ялгахын зэрэгцээ **АЛТЫГ МЭДРЭХИЙН ТУЛД** урт, богино үргэлжилсэн пульсыг дамжуулж, хүлээн авч, шинжилдэг.

**DVT** – Хос хүчдэлийн технологи илүү гүнд илрүүлэх боломж бүрдүүлэн хөрсөнд **УЛАМ ИХ ТЭЖЭЭЛ** өгөхийн тулд 2 хүчдэлийн түвшинд пульс ашиглана.

**SETA** – Ухаалаг электрон горимын тохиргоо **ДЭЭД ЗЭРГИЙН ГҮНД**, **БҮХ** төрлийн хөрсөнд маш нарийн хөрсний горимын тохиргоог ашигладаг.

## Хөрсний горимын сонголтууд




**Мэдрэмтгий (ЗӨВХӨН GPX 5000)**
Monoloop таваг ашиглаж байсан ч гэсэн **хамгийн их саад бэрхшээлтэй**, их эрдэсжсэн, хувьсамтгай, "халуун чулуугаар" дүүрсэн хөрсөнд ажиллах чадвартай.

**Сайжруулсан (Боловсронгуй болгосон)**
Маш их эрдэсжсэн, хувьсамтгай, "халуун чулуугаар" дүүрсэн хөрсөнд Monoloop таваг ашиглан чимээгүй ажиллана. Мэдрэмтгий горимоос илүү мэдрэмжтэй бөгөөд илүү гүнд илрүүлэх боловч хүчтэй эрдэсжсэн хөрсний нөлөөлөлд илүү автаж болзошгүй.

**Жижиг NEW (ЗӨВХӨН GPX 5000)**
Сайжрууулсан горимоор олж чадахгүй **маш жижиг цул алтыг** олно. Сайжруулсан горимоос илүү мэдрэмтгий бөгөөд илүү гүнд илрүүлнэ.

**Давслаг/Алт NEW (ЗӨВХӨН GPX 5000)**
Давслаг, эрдэсжсэн хөрсөнд жижиг, том алтыг мэдэрч, маш сайн дохио өгнө. Давстай нуур, далайн эрэг дээр маш сайн ажиллана.

**Хэвийн**
Олон төрлийн хөрс, янз бүрийн хэмжээтэй объектод маш сайн ажиллана. Шинэ орчинг үнэлэхэд энэ нь сайн өгөгдмөл горим юм.

**Давслаг-Том (ЗӨВХӨН GPX 4800)**
Давслаг, эрдэсжсэн хөрсөнд том цул алт олно.

**Илүү мэдрэмтгий**
Багаас дунд зэргийн эрдэсжилттэй хөрсөнд жижиг хэмжээтэй алт байгааг илтгэхээр хамгийн сайн дохио өгнө.

**Хурц**
Бага зэрэг эрдэсжсэн хөрсөнд янз бүрийн хэмжээтэй объект олно. Хэвийн горимтой төстэй боловч илүү хүчирхэг. Гүний хувьд илүү хүчин чадалтай боловч саад, хөрсний дуу чимээнд илүү мэдрэмтгий.

**Зоос/Эртний эд зүйлс NEW**
Огт эрдэсжилтгүйгээс эхлээд маш бага эрдэсжсэн талбайд дунд зэргээс том хэмжээтэй объектыг илрүүлэхийн тулд үлэмж их гүнд ажиллах боломж олгоно.